

Саналыг дараах хаягт ирүүлнэ үү.

БОАЖЯ-ны Усны нөөцийн хэлтсийн мэргэжилтэн  
Х.Сэвжидмаа

Утас: 51-267549

Майл: [sevdjmaa@mne.gov.mn](mailto:sevdjmaa@mne.gov.mn)

## **РАШААНЫГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ ЖУРМЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2018 он

Улаанбаатар хот

УИХ-ын шинэчлэн баталсан 2012 оны Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 дахь хэсэгт Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран “Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам батлах” гэж заасныг үндэслэн энэхүү журмыг шинэчлэн боловсруулсан болно.

Уг журмыг боловсруулахдаа Усны тухай болон Байгалийн нөөц ашигласны, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиудыг үндэслэн холбогдох байгууллагуудын саналыг тусган дээрх хууль эрх зүйн заалтуудад нийцүүлэн боловсруулсан.

Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам нь нийтлэг үндэслэл, рашааны нөөцийн хайгуул, судалгаа, рашааны ордыг гэрчилгээжүүлэх, рашааныг хамгаалах, рашааныг ашиглах, төлбөр тооцох үзүүлэлт, рашааны орд, эх булгийн чанарын хяналт, рашааны ашиглалт, хамгаалалтын мэдээ, тайлан гаргах, бусад гэсэн агуулга бүхий найман бүлэгтэй ба рашааны ашиглалтын гэрчилгээ гэсэн хэсгээс бүрдэнэ.

Байгалийн баялгийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохистой ашиглахын тулд тухайн баялгийн тархан орших зүй тогтол, нөөц, даац, анги төрөл, чанар найрлагын онцлогийг илрүүлж түүний үндсэн дээр ашиглалтын горимыг тодорхойлон гаргадаг.

Манай оронд нийт 267 халуун, хүйтэн рашааны орд, олон рашаан төст булгууд байдаг. Эдгээр рашаан, булгуудыг түшиглэн амралт сувиллын үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүд рашааны нөөцийг зөвшөөрөлгүй ашиглах, хэтрүүлэн ашиглах, ахуйн хаягдал ус болон бохир ус зайлуулах системээс нийлүүлсэн бохир усыг рашааны эрүүл ахуйн бүсэд хаяснаас рашаан усны нөөцийг бохирдуулах, хомсдуулах, чанар найрлага өөрчлөгдөх гэх мэт олон зөрчил, эрсдэлийг дагуулж байна. Мөн Улсын Их Хурал 2012 онд Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгад Рашааны тухай хуулийг Усны тухай хуультай нэгтгэн баталсан.

Иймээс рашаан ус болон эмчилгээний шаврын нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам батлагдсанаар рашааны нөөцийг зүй зохистой ашиглах, эзэмших, тохижуулах, рашааны усны горимд хяналт шинжилгээ хийлгэх, хэрэглээг тоолууржуулах, ашиглалтын хянах бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журамд рашаан ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд саад, хориг учруулсан аливаа хүнд суртлын нөхцөл боломж бүрдүүлсэн зохицуулалтыг агуулаагүй болно.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран батлах “Рашааныг зохистой ашиглах, хамгаалах” журмыг шинэчлэн боловсруулж танилцуулж байна.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалтыг үндэслэн ТУШААХ  
нь:

1. “Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам”-ыг нэгдүгээр, “Рашааны  
ордын гэрчилгээний загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж, рашааны эхийг хамгаалах, бохирдлоос  
сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сум, дүүргийн Засаг дарга, аймаг  
нийслэлийн Байгаль орчны алба, Сав газрын захиргаадад, хэрэгжилтэнд хяналт  
тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт,  
усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар /Ш.Мягмар/, Эрүүл мэндийн яамны  
Нийгмийн эрүүл мэндийн газар /...../-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Байгаль  
орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оны А-79/99 дүгээр  
хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Д.САРАНГЭРЭЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,  
Эрүүл мэндийн сайдын  
2018 оны... сарын ...-ны өдрийн хамтарсан  
тушаалын 1 дүгээр хавсралт

## **РАШААНЫГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь рашаан, (эмчилгээний шавар), эрдэст нуурыг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Тус журмын хэрэгжилтэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба болон тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Сав газрын захиргаа, Мэргэжлийн хяналтын байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, эрүүл мэндийн хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч тус тус хяналт тавина.

1.3. Рашааныг эмчилгээ-сувилгаа, үйлдвэрлэл-үйлчилгээний зориулалтаар ашиглаж болно.

1.4. “Эмчилгээ-сувилгаан зориулалт” гэж өвчнийг эмчлэх, сэргийлэх зорилгоор рашаан, (эмчилгээний шавар), эрдэст нуурыг тусгай горимоор хэрэглэхийг.

1.5. “Үйлдвэрлэл-үйлчилгээний зориулалт” гэж рашаан (эмчилгээний шавар), эрдэст нуурыг ахуйн хэрэгцээнд болон үйлдвэрлэл, үйлчилгээний бусад чиглэлээр ашиглахыг.

1.6. “Рашаан” гэж Усны тухай хуулийн 3.1.7-д заасныг.

1.7. “Рашааны орд” гэж Усны тухай хуулийн 3.1.8-д заасныг.

### **Хоёр. Рашааны нөөцийн хайгуул, судалгаа**

2.1. Рашаан эмчилгээний шаврын нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг тогтоох хайгуул, судалгааны ажлыг усны мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

2.2. Рашаан эмчилгээний шаврын нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг тогтоох хайгуул, судалгааны ажлыг улс, орон нутгийн төсөв, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр санхүүжүүлнэ.

2.3. Рашаан эмчилгээний шаврын нөөцийн хайгуул, судалгааны ажлын үр дүнгийн тайланд дараах үзүүлэлтүүд тусгагдсан байна:

2.3.1. Рашааны газар зүй, геоморфологи, геологийн тогтоц, тектоник бүтэц, гидрогеологийн нөхцөл;

2.3.2. Рашаан (эмчилгээний шавар)-ын физик-химийн шинж чанар, найрлагыг тодорхойлсон ажлын үр дүн;

2.3.3. Рашаан (эмчилгээний шавар)-ы физик-химийн шинж чанар, найрлагыг үндэслэн аливаа өвчнийг анагаах чадварыг тодорхойлсон

эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн байгууллагын дүгнэлт.

2.4. Рашаан ус болон эмчилгээний шаврын нөөцийн хайгуул, судалгааны ажлын үр дүнгийн тайланг Усны нөөцийн зөвлөлөөр баталгаажуулж, улсын усны мэдээллийн санд бүртгэнэ.

2.5. Хайгуул, судалгаагаар ашиглах боломжит нөөц нь батлагдсан рашааны орд бүр гэрчилгээтэй байна.

2.6. Рашаан (эмчилгээний шавар)-ы ордын гэрчилгээг тухайн сав газрын захиргаа хөтөлж, усны мэдээллийн дэд санд оруулна.

2.7. Рашаан (эмчилгээний шавар)-ы ордын гэрчилгээг тухайн сав газрын захиргаа рашаан ашиглагч, хэрэглэгчид олгоно.

### **Гурав. Рашааныг хамгаалах, ашиглах**

3.1. Рашаан (эмчилгээний шавар), эрдэст нуурыг хамгаалах харилцааг Усны тухай хуулийн 22.10-22.18 дахь хэсэгт зааснаар зохицуулна.

3.2. Рашаан (эмчилгээний шавар), эрдэст нуурын эрүүл ахуйн бүсийг хашаажуулж, хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх арга хэмжээг ашиглагч хариуцаж, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

3.3. Рашаан ашиглагч нь Усны тухай хуулийн 28.2, 28.3-т заасан баримт бичгийг бүрдүүлж, Усны тухай хуулийн 28.4-т заасан байгууллагаас зөвшөөрөл авна.

3.4. Ашиглагч нь рашааны шинж чанар, найрлагыг үндэслэсэн анагаах чадварыг тодорхойлсон дүгнэлтийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн байгууллагаар гаргуулсан байна.

3.5. Рашаан (эмчилгээний шавар), эрдэст нуурыг ашиглагч нь рашааны чанар, найрлагыг хагас жилд 1 удаа, бохирдлын үзүүлэлтүүдийн шинжилгээг ундаргын байдлаас хамаарч сард, улиралд нэг удаа өөрийн хөрөнгөөр хийлгэнэ.

3.6. Ашиглагч нь рашаан булгийн эх, нуурын эрэг орчмыг тохижуулж, түүний голдирлыг үл хөндөн шахуурга, шугам хоолойгоор авч ашиглана.

3.7. Рашааны нөөцийн хайгуул, судалгааг өөрийн хөрөнгөөр хийж, тохижуулан тоногдсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн рашааныг давуу эрхээр ашиглаж болно.

3.8. Рашаан (эмчилгээний шавар), эрдэст нуурыг ашиглах зориулалттай барилга байгууламж нь хаягдал ус, шаврыг цэвэрлэх, зайлуулах байгууламжтай байна.

3.9. Тусгай хамгаалалттай газар нутгийн хязгаарлалтын болон аялал жуулчлалын бүсэд байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар тодорхой ашиглалтын хэмжээнд багтаан ашиглана.

3.10. Рашаан (эмчилгээний шавар), эрдэст нуурыг эмчилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг Сав газрын захиргаа гаргана.

3.11. Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн рашаан ашиглах зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгож, аймаг, нийслэлийн байгаль орчны алба гэрээ байгуулан эрхийг бичиг олгоно.

### **Дөрөв. Рашаан ашигласны төлбөр**

4.1. Рашааны нөөц ашигласны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт зааснаар тогтооно.

4.2. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар рашааныг ашиглах тохиолдолд усны цооног, шугам хоолойг тоолууржуулна.

4.3. Рашаан (эмчилгээний шавар), эрдэст нуурыг ашиглан хаягдал ус, шавар гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу ус бохирдуулсны төлбөр төлнө.

4.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.2.3-т заасан хаягдал ус, шаврыг эргүүлэн ашигласан тохиолдолд тухай хэмжээгээр төлбөрөөс чөлөөлнө.

### **Тав. Рашааны орд, булгийн эх дээрх чанарын аюулгүй байдлын хяналт, шинжилгээ**

5.1. Рашаан (эмчилгээний шавар)-ы нөөцийн хайгуул, судалгааны ажлын явцад Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сав газрын захиргаа, **тухайн орон нутгийн Баг, хорооны Засаг дарга** хяналт тавина.

5.2. Ашиглагч нь рашаан (эмчилгээний шавар), эрдэс нуурын нөөц хомсдож, чанар нь алдагдахаас сэргийлж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.2.1. рашааны төрөл, газар зүйн байршил, ус зүйн тогтолцооны онцлог, ашиглалтын хугацаа, эрүүл ахуйн нөхцөл зэргээс хамааруулан рашааны худаг (цооног) улирал тутам нэг удаа хяналт шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийх;

5.2.2. нуур, рашааны эх булаг, ундарга бүрээс ашиглалтын эхний жилд сард нэг удаа дээж авч, бүх үзүүлэлтээр шинжлэн голлох үзүүлэлтийг тогтоож, дараагийн жилээс улиралд нэг удаа хяналтын шинжилгээ хийх;

5.2.3. рашааны чанарт сөргөөр нөлөөлөхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан тоног төхөөрөмжийг үйлдвэрлэл-үйлчилгээ, эмчилгээний үйл ажиллагаанд ашиглах.

5.3. Эрүүл ахуйн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх:

5.3.1. а/.газрын гүний рашаан ашигладаг улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай рашаан сувиллын нөхцөлд эрүүл ахуйн шинжилгээг улиралд нэг удаа, улирлын ажиллагаатай рашаан сувиллын нөхцөлд улиралд нэг удаа;

5.3.2. б/.ил ундаргатай рашаан ашиглаж байгаа нөхцөлд сард нэг удаа хийж гүйцэтгэнэ.

5.3.3. Рашаан (эмчилгээний шавар), эрдэст нуурын чанарын эрүүл, ахуйн үзүүлэлт (нян, нитрит, ни-трат, шүвтэр) нь бохирдлын үзүүлэлтүүд нь MNS:3651 стандартаас давсан тохиолдолд бохирдлыг бууруулах арга хэмээ авч, үр дүнг шинжилгээгээр баталгаажуулна. шалтгааныг тодорхойлох зорилгоор давтан шинжилгээ хийнэ.

## **Зургаа. Рашааны ашиглалт, хамгаалалтын мэдээ, тайлан гаргах**

6.1. Ашиглагч нь рашаан ашиглах зорилгоор цооног өрөмдсөн, тоногдсон, тохижуулсан, тэмдэгжүүлсэн тухай бүрт сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч мэдээллийг аймаг, нийслэлийн Байгаль орчны албанд хүргүүлж, бүртгүүлнэ.

6.2. Аймаг, нийслэлийн Байгаль орчны албанаас рашаан (ус болон эмчилгээний шавар), эрдэст нуурын чанар, найрлага, түвшний горимын ажиглалтын дүн мэдээг улирал тутам Сав газрын захиргаа болон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн асуудал хариуцсан газруудад хүргүүлнэ.

6.3. Байгаль орчны алба нь рашааны ашиглалт, хамгаалалт, төлөв байдлын тайлан, мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу нэгтгэж, жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлнэ.

### **Долоо. Рашааны мэдээллийн санд бүрдүүлэх материал**

7.1. Рашаан (ус болон эмчилгээний шавар)-ы эрэл хайгуулын тайлан, рашааны нөөцийн хэмжээ м<sup>3</sup>/хоног, бальнеологийн судалгааны мэдээ;

7.2. Рашаан (эмчилгээний шавар)-ы ордын мэдээлэл нь: Рашааны ордын төрөл, байршил, талбайн хэмжээ, судлагдсан байдал, батлагдсан нөөц, ашиглах боломжит нөөц, химийн найрлага, чанар, ашиглалтын бусад мэдээлэл;

7.3. Рашаан (эмчилгээний шавар)-ы эрүүл ахуйн, хамгаалалтын бүсийн хил зааг;

7.4 Рашаан (эмчилгээний шавар)-ы ашиглалтын хэмжээ, хяналт шалгалтын дүн, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт болон бусад мэдээллүүд;

### **Найм. Бусад**

8.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,  
Эрүүл мэндийн сайдын 2018 оны ..... ..  
дугаар хамтарсан тушаалын 2 дугаар  
хавсралт

РАШААНЫ ОРДЫН ПАСПОРТ

2018 он